

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 оны 11 дүгээр 15-ны өдөр

Сайншанд сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтод түвшин	Хэрэгжилт
ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЕРӨНХИЙ ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД			
1	Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх, иргэн төвтэй төрийн үйлчилгээг төгөлдөржүүлэх /цахимжуулах/	Төрийн үйлчилгээг цахимжуулсан байна.	Тус хэлтэс нь тайлант хугацаанд нийт иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 50 854 бүртгэл хийж цахимжуулсан.
2	УИХ, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотойгоор холбогдох хууль тогтоомжийг сурталчиллах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн онцлогхууль тогтоомжийн зохицуулалтын талаар салбар, байгууллагын хүрээнд мэдээлэл түгээх	Сургалт зохион байгуулж, мэдээлэл түгээсэн байна.	УИХ, аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотойгоор "Шилжилт хөдөлгөөний зогсоосон тухай" мэдээллийг орон нутгийн телевиз болон цахим хаягаар мэдээлэл түгээсэн. Мөн Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад Сонгуулийн тухай хууль тогтоомж, тус байгууллагын гүйцэтгэх үүрэг, сонгуулийн ирцийн программыг ажиллуулах сургалтуудыг зохион байгуулсан.
3	Төрийн албаны анхан дунд шатан дахь хүнд суртлыг арилгах, таслан зогсоох, иргэд хувийн хэвшлийг чирэгдүүлж, авилга үүсгэх нөхцөл бүрдүүлж байгаа үйл ажиллагаа, чиг үүргийн талаар дүгнэлт хийж, эрсдлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх	-	Бүртгэлийн үйл ажиллагаанд хувь хүний нууцыг чандлан хадгалах, иргэний бүртгэлийг иргэн зөвхөн өөрөө хүсэлт гаргасны үндсэн дээр хийх, хүсэлт гаргасан иргэний зөвхөн хурууны хээгээр бүртгэлийн үйлчилгээг явуулж хэвшээд байна. Энэ нь хүнд суртлыг арилгах, таслан зогсоох, иргэд хувийн хэвшлийг чирэгдүүлж, авилга үүсгэх нөхцөлийг таслан зогсоосон.

СОЁН ГЭГЭРҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

4	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэмжээг баримтлах, ёс суртахууныг төлөвшүүлэх сургалт, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>Сургалт зохион байгуулсан байна.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн Дорноговь аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Н.Баттуяаг урьж "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, хуулийн хэрэглээ" сэдвээр сургалтыг албан хаагчдад зохион байгуулсан. Тайлант хугацаанд төрийн албаны тусгай шалгалтанд тэнцэж шинээр томилогдсон 3 албан хаагч 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр Төрийн албан хаагчийн Тангараг өргүүлсэн.</p>
5	<p>Төрийн албан хаагчдад төрийн, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах</p>	<p>Сургалт, үйл ажиллагаа зохион байгуулсан байна.</p> <p>Мөн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор сонгуулийн Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнууд аймгийн Тагнуулын хэлтсийн албан хаагч О.Эрдэнэ-Очир "Төрийн, байгууллагын болон хувь хүний нууцтай холбоотой хууль тогтоомж"-ийн талаар сургалт зохион байгуулсан ба бүх ажилтнууд тагнуулын байгууллагад нууцын баталгаа гаргасан. Мэдээлэл технологийн ажилтан сар бүр улсын бүртгэгч нараас нууцын баталгаа гаргуулж бүртгэгч нарын комьютер болон программын нэвтрэх нууц үгийг сольдог.</p>

ТАЙЛАН БИЧСЭН:

УЛСЫН БҮРТГЭГЧ

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА

Г.НАНДИН-ЭРДЭНЭ

Ц.ТЭГШЖАРГАЛ

